



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.04.21 № 393
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан бүрэн эрхийн хүрээнд 2026 оны Ханхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох "Ардчилсан нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2026 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2026 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Ардчилсан нам”-ын Ханхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Ардчилсан нам”-ын мөрийн хөтөлбөр (11..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Ханхонгор сумын Ардчилсан намын хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ХАНХОНГОР СУМЫН АРДЧИЛСАН НАМААС ДЭВШҮҮЛСЭН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



ХАНХОНГОР СУМЫН АРДЧИЛСАН НАМААС ДЭВШҮҮЛЖ БУЙ
ИРГЭН БҮРИЙГ ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ, ЭХ ОРОНТОЙ,
ЭРҮҮЛ ЧИЙРЭГ, ЭРДЭМ МЭДЛЭГТЭЙ, ЭЛБЭГ БАЯН
БАЙЛГАХ ӨМНӨГОВЬ НУТГИЙН ХИШИГ-2028
ХӨТӨЛБӨР

Х

Эдийн засгийн өсөлтийн зорилго, зорилт

Мэдлэгийн эдийн засаг, технологийн дэвшил, ногоон хөгжил болон уул уурхайд түшиглэсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, тээвэр логистик, палеонтологи, архиелог, экологи, үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж, тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгоно.


- Зорилт 1.** Иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэн, өрхийн орлогыг өсгөх замаар оролцоотой эдийн засгийг хөгжүүлж, дундаж давхаргыг тэлнэ.
- Зорилт 2.** Мэдлэг, өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэх орчин бүрдүүлж, экспортод гаргахад дэмжлэг үзүүлнэ.
- Зорилт 3.** Сумын эдийн засгийг уул уурхайгаас гадна эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, тээвэр логистик боловсрол, шинжлэх ухаан технологи зэрэг олон тулгуурт бүтэцтэй болгоно.
- Зорилт 4.** Сумын зөөлөн, хатуу дэд бүтцийг хөгжүүлэх замаар аймгийн бизнесийн орчинг сайжруулж, өрсөлдөх чадвартай хувийн хэвшлийг бий болгоно.
- Зорилт 5.** Төрийн болон хувийн секторын цахим шилжилтийг түргэтгэх замаар үр өгөөжийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулна.

ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт, зузаан дундаж давхарга

1. Ханхонгор сумын иргэдийг ажлын байраар хангах, өрхийн орлого нэмэгдүүлэх зорилгоор “Өсөлтийг Өрх Бүрд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
2. Малчдын орлогыг нэмэгдүүлэх, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, улирлын нөлөөнөөс бага хамааралтай зорилготой “Чинээлэг малчин” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
3. Малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөрийг хөнгөвчлөх, бэлчээрийг усжуулах, бэлчээр ашиглалтыг сайжруулах, малчдын ундны усыг эрүүл ахуйн стандарт нийцүүлэх, малжуулах чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
4. “Нутгийн үйлдвэрлэгч” хөтөлбөрийг хэрэгжүүлж сумын бизнес эрхлэгч аж ахуйн нэгжийг өрсөлдөх чадвартай болгох, санхүү, хөрөнгө оруулалтын орон нутгийн эх үүсвэртэй болгоно.
5. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын “Аялал жуулчлалыг – Бүх нийтэд” уриалгыг хэрэгжүүлж Орон нутгийн иргэдийн аялал жуулчлалаас хүртэх ашиг орлогыг нэмэгдүүлнэ.
6. Залуучууд, гарааны бизнес эрхлэгчдийн ажлын байр, санхүү, хөрөнгө оруулалт,

- технологи, инновацыг дэмжих бодлогын цогц хөтөлбөр хэрэгжүүлнэ.
7. Говь нутгийн онцлогийн шингээсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлж, чөлөөт уран бүтээлчдийг дэмжих замаар соёлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
 8. Сумын төвийн гэр хорооллыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор “Шинэ хороолол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
 9. Суманд “Шинэ Мянган Айл” орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд залуу гэр бүл, төрийн албан хаагч, эмч, багш, хууль хүчний байгууллага, цэргийн хүрээний ажилтан, албан хаагчдыг орон сууцны нөхцөлийг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ.
 10. Сумын айл бүр, алслагдсан нутгийн иргэд, төрийн байгууллагын ажилтан албан хаагчдыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд бүрэн холбоно.
 11. Мэдээлэл харилцаа холбооны шинэ техник, аж үйлдвэрийн IV, Инновацын 2.0 эрин үеийн технологийн дэвшлийг бүх шатанд ашиглалтыг нэмэгдүүлэх зорилготой “Цахим Ханхонгор” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
 12. Нар, салхины зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглан, эрчим хүчний дотоодын хэрэгцээг хангах улмаар экспортыг бодлогоор дэмжинэ.
 13. Сумын төвийн газрын цэвэр ус, бохир ус, дулааны шугамд айл өрхийг холболтыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
 14. Сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжийн бизнес эрхлэхтэй холбоотой хяналт, шалгалтыг давхардуулахгүй, төрийн ямар нэгэн дарамт үзүүлэхгүй байх бодлого хэрэгжүүлнэ.
 15. Даланзадгадаас Ханхонгор сум чиглэлийн хатуу хучилттай автозамын ажлыг бүрэн дуусгаж, байнгын ашиглалтад оруулна.
 16. Ханхонгор сумын Шар цав орчмын хатуу хучилттай автозамын дагуу жуулчид, зорчигчдод зориулсан үйлчилгээний хэсгийн дэд бүтэц, ариун цэврийн байгууламж, зам талбайг байгуулна.
 17. Ханхонгор сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Төлөвлөлтийн дагуу хот байгуулалтын инженерийн цэвэр, бохир ус, дулаан, цахилгаан зэрэг дэд бүтэц, шинэ соёлын коллеж, шинэ эмнэлэг зэрэг нийгмийн үйлчилгээний бүтээн байгуулалтыг хэрэгжүүлнэ.
 18. Ханхонгор сумын төвд эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны хорооллыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.



И

Боловсролын салбарын зорилго, зорилт

Иргэд, хүүхэд, залуус олон талт боловсролыг хүртээмжтэй олох нөхцөлийг бүрдүүлэн, тэдний гэр бүл, сургуулийн орчинд зөв төлөвшил, хүмүүжил, сурах арга барил эзэмшүүлэх замаар аль ч орны хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх

- Зорилт 1.** Цэцэрлэг, сургуулийн хамран сургалтыг зохих түвшинд байлгаж, хүүхэд, залуусын сурах бүтээлч орчинг бүрдүүлнэ.
- Зорилт 2.** Багшийн ажиллах, амьдрах орчинг сайжруулах бодлого хэрэгжүүлэх замаар багш, боловсролын салбарт ажиллагчдад мэдлэг ур чадвар, заах аргазүйгээ тасралтгүй хөгжүүлэн ахиулах нөхцөл бий болгоно.
- Зорилт 3.** Жил бүр гадаад, дотоодын шилдэг их сургуульд сурах оюутны тоог нэмэгдүүлэх бодлого баримтална. Тус бодлогын хүрээнд боломжит их сургуультай хамтарсан тэтгэлгийн сан байгуулах бодлого хэрэгжүүлнэ.
- Зорилт 4.** Сурагч, залуус, иргэдийг Өмнөговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, өөрийн дур сонирхолтой мэргэжлээр сурах боломжийг бүрдүүлнэ.
- Зорилт 5.** Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг шинээр байгуулж, шинэ төрлийн мэргэжил эзэмших ангиудыг нээж, хэрэгцээт мэргэжлээр суралцахыг бодлогоор дэмжинэ.
- Зорилт 6.** Бүх насны иргэд байнга сурч боловсрох, шинэ мэргэжил, ур чадвар эзэмших, тасралтгүй өөрийгөө хөгжүүлэх боломжоор хангана.

ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

19. Сумын харьяат, ажиллаж буй багш нарыг гадаадад сурах, мэргэжил дээшлүүлэх боломжоор хангах зорилгоор "Чадварлаг багш" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
20. Орон нутагтаа тогтвор суурьшилтай, амжилттай ажиллаж байгаа төрийн албан хаагч, иргэдийг гадаад оронд туршлага судлуулах, мэргэшүүлэх "Хөгжлийн гүүр" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
21. Өмнөговийн харьяат болон чадварлаг мэргэжилтнүүд аймаг, орон нутагтаа ирж ажиллахыг бодлогоор дэмжин "Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
22. Суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах аргазүйд суралцах, тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэших хүсэлтэй сургуулийн өмнөх болон бага боловсролын багш боловсон хүчнийг дэмжих замаар хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах нөхцөлийг сайжруулна.
23. Суралцахуйн болон оюуны бэрхшээлтэй хүүхдэд тусламж дэмжлэг үзүүлэх сайн

- дурынханд орон нутгаас урамшуулал олгох тогтолцоо бүрдүүлж, “Туслах багш – Сүүдэр багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
24. Цэцэрлэгүүдэд “Зуны цэцэрлэг” хөтөлбөр хэрэгжүүлэхийг дэмжиж, зах зээлийн зарчмаар ажиллах чөлөөт боломжийг нээнэ. Ингэснээр асран хамгаалагчид ажил хийх, хүүхэд аюулгүй орчноор хангагдах, багш нар нэмэлт орлого олох боломжтой болно.
25. Сургалтын үйл ажиллагаа явуулдаг иргэн, байгууллага холбогдох хууль дүрмийн хүрээнд стандартад нийцсэн өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхийг бодлогоор дэмжинэ.
26. Цэцэрлэг, сургууль, дотуур байрны хоолны амт, чанарыг сайжруулах ялангуяа сумдын дотуур байрны гал тогоо, хоол бэлтгэлийн орчин нөхцөлийг сайжруулна.
27. Дунд, ахлах ангийн сурагчдыг дотоод гадаадын олон улсын сургуулиудад урт болон богино хугацаагаар суралцах боломжийг олгох зорилгоор “Сурагч солилцоо” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
28. Элсэлтийн ерөнхий шалгалт болон олон улсын шалгалтын үнэлгээнд өндөр оноо авсан багш, сурагчдыг тэтгэн урамшуулах тогтолцоо бүрдүүлнэ.
29. Сургуулийн номын сангийн үйлчилгээг сайжруулах “Найз номын сан” хөтөлбөр хэрэгжүүлж, номын фондыг баяжуулж, уншлагын танхимын орчин нөхцөл, ялангуяа гэрэлтүүлгийг олон улсын стандартын дагуу тавьж тохижуулан, ном ариутгах төхөөрөмжөөр хангана. Мөн “цахим номын сан” нэвтрүүлэн, ном бүртгэлийг цахимжуулах, номын санчийг чадавхжуулах, ажлын үр дүн, уншигчийн тоогоор алдаршуулах, орон нутгаас урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
30. Бага, дунд ангийн сурагчдыг “Үдийн хоол”, ахлах ангийн сурагчдыг “Үдийн цай” хөтөлбөрт хамруулж, идэвхтэй сурах үйл ажиллагааг дэмжин, хоол тэжээлийн хомсдолд орох, ходоодны өвчлөлөөс сэргийлнэ.
31. Бага ангийн багш, сувилагч зэрэг орон нутагт нэн тулгамдаж буй боловсрол, эрүүл мэндийн салбарын мэргэжлийн боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэхэд чиглүүлэн “Цалинтай оюутан” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
32. Жил бүр гадаад, дотоодын шилдэг их сургуульд урт богино хугацаагаар суралцах оюутны тоог нэмэгдүүлж, боломжит их дээд сургуультай “Оюутан солилцоо” хөтөлбөр хэрэгжүүлнэ. Мөн орон нутагтаа “Олон улсын боловсролын яармаг” тогтмол зохион байгуулж, гадаадад суралцах зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээг дэмжинэ.
33. Үндэсний болон олон улсын шалгалт үнэлгээ, уралдаан, тэмцээн, олимпиадад өндөр оноо авсан, амжилт гаргасан багш, оюутныг урамшуулдаг тогтолцоотой бүрдүүлж, хөшүүргийг оновчтой болгоно.
34. Малын эмч, малзүйч, ойн инженер, агрономич зэрэг мэргэжлээр нас харгалзахгүй суралцахыг бодлогоор дэмжиж, хөдөө аж ахуйн салбарт дутагдаж байгаа хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэнэ.
35. Хүүхэд, залуус, иргэд, олон нийтэд зориулсан сургалт, судалгаа, солилцоо явуулдаг орон нутагт бүртгэлтэй аливаа боловсролын байгууллага, иргэний санаачилга, ашгийн болон ашгийн бус үйл ажиллагааг дэмжих нээлттэй бодлого хэрэгжүүлнэ.
36. Үндэсний болон бусад орон нутгийн онцлогтой спортыг хөгжүүлэх хөтөлбөр

- хэрэгжүүлж, сумдын хүн амын өсөлт, хөгжлийн хэрэгцээнд тулгуурлан спорт заал, спорт талбай, спорт цогцолбор барьж байгуулах, тоног төхөөрөмжөөр хангах, бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх орчинг бүрдүүлнэ.
37. Бүх салбарын цахим шилжилтийг түргэтгэхийн тулд “Цахим ХАНХОНГОР” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, бүх нийтийн цахим хэрэглээний ур чадвар, цахим орчин дахь мэдээллийн аюулгүй байдал, харилцаа хандлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.
38. Хүүхэд, залууст зориулсан компьютер программчлал, инженерчлэл, математик, мэдээлэл зүй, роботикс, техник загвар, кодингийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага, иргэдийг дэмжих бодлого баримталж, суманд STEM сургалтын төвүүдийг байгуулна.
39. Математик, физик болон байгалийн шинжлэх ухааны багш нарыг STEM боловсролын чиглэлд чадавхжуулах, олон улсын туршлага судлах, сургалтын шинэ аргазүй нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ.
40. Сумын номын сангийн хөгжлийг шинэ түвшинд гаргах зорилгоор “Нутгийн номын сан” хөтөлбөр хэрэгжүүлнэ. Номын санчийг чадваржуулах, ном бүртгэлийн дэвшилтэт программ ашиглах нөхцөлийг сайжруулах, уншлагын танхимыг тохижуулах, номын фондыг өргөжүүлж, найдвартай интернэт сүлжээгээр хангах, “Цахим номын сан” ашиглах боломж нээх, номын сангийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, уншигчийн тоогоо нэмэгдүүлсэн номын санчийг урамшуулах тогтолцоо бий болгоно. Бүх нийтийн эрүүл мэндийн боловсрол, өсвөр насныхны бэлгийн боловсрол, залуучуудын гэр бүл төлөвлөлтөд чиглэсэн сургалтуудыг дэмжинэ.
41. Хүүхэд, залуус, иргэдийн урлаг, спорт, гоо зүйн боловсролыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
42. Бүх нийтийн эрүүл мэндийн боловсрол, өсвөр насныхны бэлгийн боловсрол, залуучуудын гэр бүл төлөвлөлтөд чиглэсэн сургалтуудыг дэмжинэ.
43. Бүх нийтийн монгол уламжлал, ёс заншил, байгаль, экологийн боловсролыг дээшлүүлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ.
44. Бүх нийтийн англи хэлний боловсролыг дээшлүүлэх чиглэлд үйл ажиллагаа явуулж буй иргэний санаачилга, байгууллагыг гаргасан амжилт, үр дүнд нь суурилан урамшуулдаг тогтолцоог бий болгоно.
45. Бүх нийтийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
46. Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ. Мөн бүх нийтэд зориулсан төслийн менежментийн сургалт, насанд хүрэгчдэд зориулан нягтлан бодох бүртгэлийн эчнээ сургалт зэргийг орон нутагтаа зохион байгуулахыг бодлогоор дэмжинэ.
47. Малчид, өрхийн үйлдвэрлэл, хувийн бизнес эрхлэгчид, гарааны аж ахуйн нэгжүүдийг чадавхжуулах, өрсөлдөх чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ур чадварын сургалтуудыг тогтмол явуулах, гадаад дотоодод туршлага судлахад нь дэмжлэг үзүүлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Ш

Засаглалын хөгжлийн зорилго, зорилт

Хувь хүний халдашгүй байдал, хууль ёсны эрх, ашгаа хамгаалуулах, шударгаар шийдвэрлүүлэх, гэм буруутай нь шүүхээр тогтоогдоогүй байхад ял зэм хүртэхгүй, хуулиас гадуур мөрдөн шалгагдахгүй байх, ялгаварлал, хүчирхийллээс ангид, айдасгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ

- Зорилт 1. Хүний эрхийг дээдэлсэн, иргэдийн оролцоог хангасан, ил тод, ёс зүйтэй, шуурхай төрийн үйлчилгээг оновчтой бодлогоор удирдана
- Зорилт 2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, авлига, хүнд сурталгүй, иргэдийн эрэлтийг хангасан үйлчилгээг бий болгоно.
- Зорилт 3. Сумын бүх шатны удирдлага иргэдийн оролцоотой шийдвэр гаргадаг, тэр шийдвэр нь ил тод, шуурхай хүртээмжтэйгээр иргэдэд хүргэдэг болно.
- Зорилт 4. Орон нутгийн иргэдийн тэгш оролцоог хангаж, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхах байдлыг устгана.
- Зорилт 5. Ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангах зорилгоор “Цахим засаглал” бий болгоно.
- Зорилт 6. Хүний эрх, иргэний оролцоо, өөрийн зохицуулалтын чиглэлд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, сайн дурын үйл

ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

48. Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоо, хяналтыг сайжруулна. Сумын ИТХ-ын төлөөлөгчид болон иргэд, сонгогчдын эргэх холбоог нэмэгдүүлнэ.
49. Иргэн цахим санаачилга гаргасан, иргэд цахимаар гарын үсэг цуглуулж тодорхой асуудлыг дэвшүүлсэн тохиолдолд аймаг, сумын ИТХ шууд авч хэлэлцэх журам тогтооно.
50. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
51. Нутгийн өөрөө удирдах ёс болон төрийн захиргааны байгууллагын гаргасан бодлого, шийдвэрийн үр нөлөөг бодлогын судалгааны хүрээлэнгээр дамжуулан үнэлдэг болгоно.
52. Ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангах зорилгоор Цахим засаглал бий болгоно.
53. Цахим орчны эрх зүйн харилцааг боловсронгуй болгох, цахим орчинд хүний нэр

төр, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, байгууллага, хувийн мэдээлэл, нууц, өгөгдлийн аюулгүй байдлыг хангана.

54. Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.

55. Төрийн албаны мерит зарчмыг хадгална.

И

Эрүүл мэндийн салбарын зорилго, зорилт

Сумын хүн бүрийн эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эрүүл дадал хэвшилтэй, идэвхитэй амьдралын хэв маягтай иргэн улмаар эмчлэх замаар дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд оршино

- Зорилт 1.** Хүн амыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлж, өвчнийг эрт илрүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- Зорилт 2.** Эмнэлгүүдийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. Бүсийн эмчилгээ, оношилгооны төвийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлнэ.
- Зорилт 3.** Иргэдийг эрүүл дадал хэвшил, амьдралын идэвхтэй хэв маягт уриалсан бодлого хэрэгжүүлнэ.
- Зорилт 4.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэд идэвхтэй сурч, хөдөлмөрлөх, орлогоо нэмэгдүүлж, нийгмийн харилцаанд ороход тэгш, хүртээмжтэй, тогтвортой нөхцөлийг бүрдүүлнэ.
- Зорилт 5.** Эмч, сувилагч, эрүүл мэндийн салбарын мэргэжилтний тоо, хүрэлцээг нэмэгдүүлнэ. Тэдний амьдрах орчин, нийгмийн хамгааллыг сайжруулна.

ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

56. Иргэн бүр эрүүл мэндийн байгууллагаас чанартай, соёлтой үйлчилгээ хүртэхэд чиглэсэн зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ. Ингэхдээ эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх, эмнэлгүүдийг өргөтгөх болон шинээр эмнэлэг барих бодлого баримтална.
57. Иргэн бүрийг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагдахыг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ. Эрт илрүүлгийн нэгдсэн төв, оношилгооны иж бүрэн лабораторийг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлнэ.
58. Хүн амын эрүүл чийрэг байхад зориулагдсан спорт заал, бялдаржуулах төвүүдийг нэмэгдүүлнэ.
59. “Эрүүл элэг”, “Эрүүл шүд” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, хавдрын химийн эмчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

60. Өсвөр насныхан болон насанд хүрэгчдэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн боловсрол олгох цогц нөлөөллийн ажил явуулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах, эрт оношлуулах, эмчлүүлэх ач холбогдолтой талаар олон нийтэд зөв ойлголт өгөх, оношилгоо, эмчилгээ, нөхөн үржихүйн асуудлаарх олон нийтийн хүний эрхийн мэдрэмжийг дээшлүүлнэ.
61. Хүүхэд залуусын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи болон цахим тоглоом, видео контентод донтох, сэтгэцэд нөлөөлөх бодист мансуурах зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ. Ноирны дутагдлаас үүссэн мэдрэлийн ядаргаа, сэтгэл түгшилт, сэтгэл гутралаас сэргийлэх, уур бухимдал тайлах идэвхтэй аргуудыг сурч, сэтгэл хөдлөлийн ур чадваруудыг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нэвтрүүлнэ.
62. Хувийн хөрөнгө оруулалтаар спорт, бялдаржуулах клуб, эрүүл зөв амьдралын хэв маягийг ард иргэдэд хэвшүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
63. Эх хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөрийг боловсронгуй болгож, эх хүүхдийн хоол тэжээлд дэмжлэг үзүүлэх "Сүү тараг" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
64. Агаарын бохирдол, тоосжилт, хөрсний бохирдол, хорт ургамлаас шалтгаалсан харшлын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор "Харшлын эсрэг тэмцье" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
65. Иргэдийн хүнсний бүтээгдэхүүнээ зөв сонгох, аюулгүй хүнс хэрэглэхийн ач холбогдол болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээнээс татгалзах зан үйлийг дэмжинэ.
66. Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж, Хүнсний хангамж-аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүнсний хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.
67. Хүн амыг стратегийн эрүүл, аюулгүй хүнсээр хангах ажлын хүрээнд эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан мал нядалгааны газрыг сумдын төвүүдэд байгуулна.
68. Гэр бүл болон иргэд хамтран нийгэмд хорших маягаар хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх санал санаачилгыг дэмжинэ.
69. Ахмадын амралт сувиллын газар, хоол тэжээлийн төвийг суманд байгуулна. Ахмад настны хөгжил, хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор зарим сумдад ахмадын хөгжлийн өргөөг сумдад байгуулна.

Г

Байгаль орчны салбарын зорилго, зорилт


Говь цөлийн бүсийн экологийн тэнцвэрийг хангах, хүрээлэн буй орчны унаган төрхийг хэвээр хадгалан үлдээх, хүний буруутай үйл ажиллагаа, уул уурхайн хайгуул, олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрлэлээс байгалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгал орчны хэтийн бодлогын удирдлагыг орон нутгийн түвшинд оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх.

- Зорилт 1.** Иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын оролцоотойгоор байгаль хамгаалах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах төсөл, хөтөлбөр, нөлөөллийн ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ.
- Зорилт 2.** Агаар, хөрс, ус, гэрлийн бохирдлыг зөвшөөрөгдөх хэмжээнд хүргэх буюу хадгална. Гэр хорооллоос үүдэлтэй орчныг бохирдлыг бууруулна. Хуурай технологийн жорлонг байгуулна.
- Зорилт 3.** Байгал орчинд хохирол учруулсан аливаа хуулийн этгээд, иргэнд зохих хариуцлагыг хүлээлгэж хохирол барагдуулах механизмыг боловсронгуй болгоно.
- Зорилт 4.** Уул уурхайгаас үүдэлтэй байгаль орчны бохирдлуудыг бууруулна. Хууль бус лицензийг цуцалж, эвдэгдээгүй газар нутгийг унаган төрхөөр нь хадгалан хамгаалж, аялал жуулчлалын шинэ зорих газрыг бий болгоно.
- Зорилт 5.** Сумын нийт газар нутаг, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.
- Зорилт 6.** Биологийн олон янз байдал, тэр дундаа ховордож буй амьтан, ургамлыг хамгаална. Байгалийн өвт газруудын хамгаалал, ашиглалтыг орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.
- Зорилт 7.** Байгал орчинд халгүй технологи нэвтрүүлэхэд шаардлагатай санхүүгийн хөшүүрэг бий болгож, энэ чиглэлд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжинэ.

ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

70. Зэрлэг амьтны усны эх үүсвэрийг нэмэгдүүлж, бага гүний худаг гаргах, дарагдсан булаг, худгийг сэргээнэ.
71. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулахад олон улсын ба мэргэжлийн байгууллага, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ. Ийм газрын тодорхой хэсгийг нутгийн иргэдийн бүлэг, нөхөрлөлд менежментийн гэрээгээр ашиглуулах бодлого хэрэгжүүлнэ.
72. Зэрлэг амьтан судлах хамгаалах тусгай сонирхлын аяллыг хөгжүүлэх

- зорилгоор алслагдсан, говь цөлийн бүс газар нутгуудад зэрлэг амьтад, нүүдлийн зүйлүүдэд зориулсан усалгааны цэг, хөв цөөрмийг байгуулж, Экологийн коридор – Холбоос нутгийг байгуулна.
73. Орон нутгийн иргэдийн Байгал хамгаалах нөхөрлөл, ТББ-ыг хөхиүлэн дэмжиж байгаль хамгааллын үр шимийг хүртэх боломжийг бий болгоно.
74. “Хашаандаа сайхан амьдарцгаая” аяныг өрнүүлж иргэдийг хашаандаа ая тухтай сайхан амьдрах дэд бүтцээр хангана. Аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжийн ашигт ургамал, жимс жимсгэнэ, алим тариалалтыг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
75. Агаарын бохирдол, хөрсний бохирдол, экологийн хүчин зүйлийн зэрэг байгаль орчны үзүүлэлтүүдийг тогтмол хэмжиж, үр дүнг дүгнэж байна.
76. Задгай булаг шанд, баян бүрд, горхи, гадаргад ойрхон уст цэгүүдийг дайруулан ногоон бүс байгуулах иргэд, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг дэмжинэ.
77. Сумын усны нөөц, чанарын, хяналтын нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлж, газар нутгийн усны судалгаа, шинжилгээ, ашиглалт, хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгоно.
78. Сумын газар тариалан, ногоон байгууламж, таримал ойн сангийн усны эх үүсвэрт зориулан хөв цөөрөм, гадаргын усаар гүний усыг арвижуулах төсөл, газрын доорх далан байгуулах төслүүдийг хэрэгжүүлнэ.
79. Сумын төвийн ногоон байгууламжийг ус хангамжийн нэгдсэн, найдвартай эх үүсвэрт холбоно.
80. Хүрээлэн буй орчныг хамгаалах, байгальд ээлтэй шинэ технологи, үйлдвэрлэлийг бий болгож үр ашигтай ажлыг тууштай дэмжин ажиллана.
81. Өмнөговь аймгийн экосистем, зэрлэг байгалийн танин мэдэхүйн сурах бичиг, хичээлийн хөтөлбөр бий болгоно. Байгал хамгаалах сайн дурын клуб, хүүхдийн клуб, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.
82. Говь цөлийн экосистем, биологийн олон янз байдал, экосистемд үзүүлдэг хүний буруутай үйлдлийн сурагчид, залуучууд, иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлнэ.





**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.04.21 № 396

танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан бүрэн эрхийн хүрээнд 2026 оны Ханхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2026 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2026 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Монгол ардын нам”-ын Ханхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр (...⁶... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Ханхонгор сумын Монгол ардын намын хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ц.ӨСӨХБАЯР

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН НАМААС ДЭВШҮҮЛЖ БУЙ “ХАНХОНГОР ШИНЭ СЭРГЭЛТ” СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Энэхүү мөрийн хөтөлбөрийг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал”, Шинэ хоршоо хөдөлгөөн, Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөр, Өмнөговь аймгийн суурь судалгаанууд, иргэдийн саналд тулгуурлан “Ханхонгор Шинэ сэргэлт” мөрийн хөтөлбөрийг боловсруулав.

Энэхүү мөрийн хөтөлбөр нь 5 бүлэг, 13 дэд бүлэг, 104 заалтаас бүрдэнэ.



НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Ажилтай орлоготой - Хөгжсөн өрх

- 1.1.1 Ханхонгор сумын иргэдийн хэрэгцээнд тулгуурласан “Хөгжсөн өрх” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.2 Тусгай хэрэгцээ /Хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийн эрх, оролцоог хангаж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 1.1.3 Хүнд машин механизмын операторын сургалтыг Уул уурхайн компаниудтай хамтран зохион байгуулж сумын иргэдийг хамруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.4 Өмнөговь аймгийн Политехникийн коллежийг түшиглэн төмөр замын мэргэжилтэн, ажилтан бэлтгэх сургалтад иргэдийг хамруулан зохион байгуулна.


1.2. Ахмадаа дээдэлж - Иргэнээ халамжилна

- 1.2.1 Сумын Ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжих зорилгоор тоног төхөөрөмжөөр хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.2.2 Ахмадын хэрэгцээ, чадамжид суурилсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.2.3 Ахмад настны судалгааг гаргаж, сумын ахмадын хороотой хамтран ажиллана.

1.3. Эрүүл чийрэг - Ханхонгорчууд

- 1.3.1 Эх, хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.2 Шүдний эрүүл мэндийн кабинет нээж, мэргэжлийн боловсон хүчнээр ханган үзлэг эмчилгээ хийж эрүүлжүүлнэ.
- 1.3.3 Малчин өрхөд эмчийн үзлэг хийх давтамжийг нэмэгдүүлж иргэн бүрийг “Эрүүл шүд” хөтөлбөрт хамруулна.
- 1.3.4 Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор 2 жил тутамд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.
- 1.3.5 “Эрүүл зүрх” аяны арга хэмжээг зохион байгуулна.

- 1.3.6 Эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, нутагтаа оношлуулж, эмчлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.7 Фитнес, нийтийн бүжиг, явган аялал, зөв хооллолтын клуб зэрэг эрүүл дадал хэвшлийг бий болгох олон нийтийн байгууллагуудыг бодлогоор дэмжинэ.
- 1.3.8 Өрх бүрийн зориулалтын бус ундны усны савны хэрэглээг халж, эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усны савтай болгох аян өрнүүлнэ.
- 1.3.9 Эрүүл мэндийн төвд дутагдалтай боловсон хүчнийг бэлтгэхэд анхаарч бодлогоор дэмжинэ.
- 1.3.10 Багийн Засаг дарга, эмч нарын ажиллах нөхцөлийг сайжруулах замаар иргэдэд үйлчлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлнэ.



1.4. Боловсролоор тэргүүлсэн – Авьяаслаг хүүхдүүд

- 1.4.1 Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээлч, чадварлаг багшийг бэлтгэж, тогтвор суурьшилтай ажиллуулна.
- 1.4.2 Ханхонгор суманд Хөгжимт бүжгийн коллеж байгуулж говийн бүсийн дуу хөгжмийн багш, урлагийн ажилтнуудыг сургаж бэлтгэх, бааз суурийг бүрдүүлнэ.
- 1.4.3 Хөгжимт бүжгийн коллежийн сурагчдын авьяасыг хөгжүүлж тайлан тоглолтыг 2 жил тутамд зохион байгуулна.
- 1.4.4 Хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмолжуулж гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход анхаарч, тусгаарлах байрыг бий болгох ТЭЗҮ-г гаргана.
- 1.4.5 Хүүхэд залуучуудад эх оронч ухаарал, үзэл, үндэсний бахархлыг төрүүлэх “Сайхан бичигтэн” аян зохион байгуулна.
- 1.4.6 Аравдугаар Цэцэрлэгийг түшиглэн хүүхдийн “Зуны гэр цэцэрлэг”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулна.
- 1.4.7 Аравдугаар Цэцэрлэгийн урлагийн танхимыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.4.8 Сургуулийн сурагчдын дотуур байрыг тохижуулна.
- 1.4.9 Сурагчийн сурах орчинд анхаарч ширээ сандал, тоног төхөөрөмжийг ээлж дараатайгаар шийдвэрлэнэ.
- 1.4.10 Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, зайн сургалтаар иргэдийн амьдрах ухааны боловсролыг дээшлүүлнэ.

1.5. Хөгжлийн ирээдүй – Оюунлаг залуучууд

- 1.5.1. Орон нутагт дутагдалтай мэргэжлээр дотоодын их дээд сургуульд суралцаж буй оюутан, мэргэжил дээшлүүлж буй багш, эмч нарыг бодлогоор дэмжинэ.
- 1.5.2 Монгол хэл, бичгээрээ зөв ярьж, бичиж сурах чадварыг бий болгох зорилгоор “Хос бичигтэн” төслийг хэрэгжүүлж, үндэсний Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.
- 1.5.3 Суманд шинээр шилжин ирж тогтвор суурьшилтай 5 жил ажилласан багш нарыг орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.5.4 “Англи хэлтэй Ханхонгор” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор хүүхэд залуучуудын гадаад хэлний боловсролыг сайжруулна.

- 1.5.5 Соёлын төвийн техник хэрэгслийг сүүлийн үеийн дэвшилтэд төхөөрөмжүүдээр шинэчилнэ.
- 1.5.6 "Хариуцлагатай эцэг, эх" хөтөлбөр хэрэгжүүлж хүүхдийн эрхийг дээдэлсэн гэр бүлийг төлөвшүүлнэ.
- 1.5.7 Суманд "Залуучуудын хөгжлийн төв"-ийг байгууламжийг байгуулна.
- 1.5.8 Төрийн бус байгууллага, судлаачид, иргэдтэй хамтран сумын Соёлын өв, түүхэн хүмүүсийн үйл хэргийг сурталчилна таниулах, түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх, ном, баримтат кино бүтээл туурвих ажлыг дэмжинэ.
- 1.5.9 Сумын Музейг үзмэрээр баяжуулж соёлын өвийг хамгаална.

1.6. Урлаг, Спорт

- 1.6.1 Нийтийн биеийн тамир, үндэсний болон спортын бусад төрлүүдийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, уралдаан тэмцээн зохион байгуулах, улс, аймгийн уралдаан тэмцээнд оролцох тамирчид, мэргэжлийн холбоодыг дэмжинэ.
- 1.6.2 Үндэсний баяр наадмыг сумандаа жил бүр зохион байгуулна.
- 1.6.3 Иргэдийн идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжиж хөл бөмбөг, гар бөмбөг, сагсан бөмбөг зэрэг спортоор хичээллэх боломжийг бүрдүүлсэн нийтийн биеийн тамирын талбайг тохижуулна.
- 1.6.4 Сумын аварга шалгаруулах Адуучин тэмцээнийг тогтмол зохион байгуулна.
- 1.6.5 Сайхны Сарлаг, Говь фестиваль, Ингэний айргийн баяр зэрэг арга хэмжээнд малчдаа өргөнөөр хамруулж дэмжиж ажиллана.
- 1.6.6 Улс, аймаг, сумын чанартай урлаг, спортын наадам, уралдаан тэмцээнд оролцогч иргэдээ бодлогоор дэмжинэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Хариуцлагатай төсөв -Тогтвортой хөгжил

- 2.1.1. Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай бодлогыг хэрэгжүүлж, төсвийн төлөвлөлт гүйцэтгэлд иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.
- 2.1.2. Сумын хөгжлийн мастер төлөвлөгөөний хүрээнд эдийн засгийн нөөц боломжид тулгуурлан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлж, орон нутгийг хөгжүүлнэ.
- 2.1.3. Орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник технологийг орон нутагт нэвтрүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийг бодлогоор дэмжинэ.
- 2.1.4. Залуу малчдыг дэмжих, туршлага судлуулах, малчдын эрүүл мэндийг хамгаалах, малын ашиг шимийг нэмэгдүүлэх, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулах, ашиг орлогоо нэмэгдүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.1.5. МУЗГ-с хэрэгжүүлж байгаа Шинэ хоршоо хөдөлгөөнийг малчдад сурталчилна таниулж ажиллана.
- 2.1.6. Малын халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн эрүүлжүүлэх арга хэмжээг авч, бог малыг ариутгал, халдваргүйжүүлэлтэд бүрэн хамруулах ажлыг үргэлжлүүлнэ.

- 2.1.7. "Эрүүл мал", "Цэвэр цэмцгэр өвөлжөө" аяныг өрнүүлж, бүх өвөлжөөг ариутгана.
- 2.1.8. Өөрийн хөрөнгөөр шинээр худаг гаргасан болон сэргээн засварласан иргэдийг бодлогоор дэмжинэ.
- 2.1.9. Малын үүлдэр угсааг баталгаажуулж, таваарлаг чанарыг нэмэгдүүлэн малжуулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.1.10. Мянга буюу түүнээс дээш мал тоолуулсан иргэдэд Ханхонгор сумын "Мянгат малчин" тэмдгийг үргэлжлүүлэн олгож хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.1.11. Малын бэлчээр ашиглах, хамгаалах журмыг судалж иргэдээр хэлэлцүүлэн шинэчлэн баталгаажуулж хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 2.1.12. Өөрийн хөрөнгөөр өвөлжөө бууцаа сэргээн засварласан тохижуулсан иргэдийг дэмжиж ажиллана.
- 2.1.13. Өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- 2.1.14. Нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийг хөдөөгийн худгуудад суурилуулна.

2.2. Стратегийн эрүүл, аюулгүй хүнс, үйлдвэрлэл

- 2.3.1. Газар тариалан эрхлэгчдийн хөдөлмөрийг хөнгөвчлөх, дэвшилтэд технологийг нэвтрүүлэх, туршилт судалгааны ажлыг хийж нэгжийн ургацыг нэмэгдүүлнэ.
- 2.3.2. Услалтын систем бүхий газар тариалангийн бүс нутагт усжуулалтыг нэмэгдүүлж, тариалалтын талбайг судалгаагаар нэмэгдүүлнэ.
- 2.3.3. Орон нутгийн хөрсөнд нутагшсан сортын үрийн нөөцийг бүрдүүлж, хүлэмж, зоорь агуулахын аж ахуйг хөгжүүлнэ.
- 2.3.4. Өрхийн тариалан эрхлэлтийг дэмжих зорилгоор хүлэмжийн аж ахуй эрхлэх сонирхолтой хүлэмжтэй өрхийг нэмэгдүүлнэ.
- 2.3.5. Жижиг дунд үйлдвэрлэл, нөхөрлөл, хоршоог бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.3.6. Орон нутгийн онцлогт тохирсон малын тэжээлийн ургамлын тариалалтыг бодлогоор дэмжинэ.

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО


3.1. Иргэнд үйлчилдэг - Ухаалаг төрийн алба

- 3.1.1. "Хөдөлгөөнт баг"-аар дамжуулан багийн иргэдэд төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.1.2. Нэг цэгийн үйлчилгээг бүрэн нэвтрүүлж, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөс үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, цогц үйлчилгээтэй болгоно.
- 3.1.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааныг фейсбүүк лайв /live/,-аар шууд нэвтрүүлж сонгосон төлөөлөгчийнхөө оролцоог хангадаг болно.
- 3.1.4. Төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг иргэдийн хяналтад тулгуурлан сайжруулах бодлого хэрэгжүүлж, нийтийн удирдлагын ил тод байдлыг хангана.
- 3.1.5. Эрүүл мэндийн төвд сургалт сурталчилгааны менежерийг орон тоогоор ажиллуулна.
- 3.1.6. Төрийн албан хаагчдыг хүнд суртал, авилгалаас ангид байлгаж, ёс зүй, хариуцлагыг чанд сахиулна.

- 3.1.7. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 3.1.8. Төрийн бүх байгууллагад угтах үйлчилгээг нэвтрүүлж үйлчилгээний соёлыг төлөвшүүлнэ.
- 3.1.9. Төрийн албан хэрэг хөтлөлтийг Монгол бичгээр явуулах болсонтой холбогдуулан Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн боловсролыг дээшлүүлнэ.
- 3.1.10. Иргэдээ ая тухтай, амар амгалан орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2. Аюулгүй -Амгалан сум

- 3.2.1 Сумын хэмжээнд архианаас татгалзах нөлөөллийн ажлыг зохион байгуулж “Архигүй-амар амгалан гэр бүл” аяныг хэрэгжүүлнэ.
- 3.2.2 Цахим хэрэглээг багасгах, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.
- 3.2.3 “Эрх зүйн мэдлэгийг иргэн бүрд” хөтөлбөрийг хэрэгжүүлж иргэдийн эрхээ хамгаалах боломжийг нэмэгдүүлнэ.
- 3.2.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулан, үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад анхаарч ажиллана.
- 3.2.5 Зам тээврийн аваар ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор тэмдэг тэмдэглэгээг байршуулна.



ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4.1. Хариуцлагатай уул уурхай

- 4.1.1. Орон нутгийн бичил уурхайчдыг хууль эрх зүйн хүрээнд дэмжиж ажиллана.
- 4.1.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдэд хяналт тавьж нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгүүлнэ.
- 4.1.3. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран ажиллах гэрээнд орон нутгаас ажиллах хүчнээр хангуулах тал дээр хамтарч ажиллана.

4.2. Байгаль орчин- Ногоон хөгжил- Аялал жуулчлал

- 4.2.1. Сумын хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлж мод бутны суулгац тарьж цөлжилтөөс урьдчилан сэргийлнэ.
- 4.2.2. Гадаад болон дотоодын аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн онцлогт тохирсон хөтөлбөрийг боловсруулна.
- 4.2.3. Байгаль орчин ногоон хөгжил, хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж “Эко сум” болно.
- 4.2.4. Байгаль орчны нөхөрлөл, иргэдийн оролцоотойгоор ан амьтан, ус, хөрс, ургамлыг хамгаалж, байгаль орчны нөхөн сэргээлтийг хангаж ажиллана.
- 4.2.5. Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор “Эко жорлон”-г хэрэгжүүлнэ.
- 4.2.6. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчидтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж малчид иргэдийн саналыг тусгаж ажиллана.

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1. Улсын хөгжил - Сумаас

- 5.2. Дулааны шугам сүлжээг шинэчилж, бохир усны шугам сүлжээнд айл өрхүүдийг холбоно.
- 5.3. "Миний түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хүрээнд суманд "100 айлын сууц" төслийг түрээслэх болон түрээслээд өмчлөх нөхцөлөөр орон сууцтай болгох төслийг орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- 5.4. Даланзадгад-Ханхонгор сумын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэн засварлана.
- 5.5. Бага оврын мах боловсруулах үйлдвэр, технологийн зоорь сайн хоршоо хөтөлбөрийн хүрээнд малчин иргэдийн оролцоотойгоор барьж байгуулна.
- 5.6. Хэвтэн эмчлүүлэгчдэд "Уламжлалт, сэргээн засах эмчилгээний тасгийг нээж шаардлагатай тоног төхөөрөмж, боловсон хүчнээр хангана.
- 5.7. Даланзадгад-Ханхонгор сумын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэн засварлана.
- 5.8. Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг барьж ашиглалтад оруулж дэмжиж ажиллана.
- 5.9. Соёлын төвийн өргөтгөл барина.
- 5.10. Даланзадгад- Ханхонгор замыг хатуу хучилттай замыг барина.
- 5.11. Сумын төвийг камержуулж иргэдийн аюулгүй байдлыг хангана.
- 5.12. Дөрвөн багт урлаг, спортын танхим бий болгон тохижуулна.
- 5.13. Хөдөө орон нутагт ажиллаж буй төрийн албан хаагчдад зориулсан түрээсийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ
- 5.14. Төрийн албан хаагчдын нийтийн орон сууцыг засварлана.
- 5.15. Сумын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.
- 5.16. Үүрэн телефоны операторын сүлжээг нэмж суурилуулна.
- 5.17. Усны цэг тогтоож усан хангамжийг нэмэгдүүлнэ.
- 5.18. Сумын төвд ШТС-ыг хувийн хэвшилтэй хамтарч байгуулна.